

Speech on the occasion of the His Majesty the Emperor's Birthday
Reception
(2017.11.29)

The Honourable Ministers,
The Honourable Members of the Great Khural,
Ambassadors,
Distinguished Guests,
Ladies and Gentlemen,

Засгийн газрын Эрхэм гишүүд,
УИХ-ын Эрхэм гишүүд,
Монгол улсад суугаа Элчин сайд нар,
Эрхэм хүндэт зочид,
Хатагтай, ноёд оо,

It is a great pleasure for me to host a reception to celebrate the birthday of His Majesty the Emperor. His Majesty will be turning to 84 years of age on the 23rd of December. I am honoured to have so many people engaged with the development of the relationship between Japan and Mongolia joining me here tonight on this celebration.

Өнөөдөр миний урилгыг хүлээн авч Япон Улсын Цог Жавхлант Эзэн Хааны мэндэлсэн өдөрт зориулан зохион байгуулж буй хүлээн авалтад морилон ирсэн та бүхэнд хязгааргүй их талархаж байгааг хүлээн авна уу.

Ирж буй 12 сарын 23-ны өдөр манай Цог Жавхлант Эзэн Хаан 84 насны ойтойгоо золгох гэж байгаа бөгөөд энэхүү тэмдэглэлт өдрийг хоёр орны харилцааг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулж ирсэн Та бүхнийхээ хамтаар тэмдэглэх гэж байгаадаа туйлын их баяртай байна.

This year, which marks the 45th anniversary of the establishment of diplomatic relations between Japan and Mongolia, has been extremely productive, including the mutual visit by the speaker of the respective parliament and the announcement of the new five-year mid-term action program to further substantiate our strategic partnership. It is difficult to enumerate so many of the cultural exchange events and joint symposiums

celebrating this important milestone, which has been made possible with the huge support of people in our two countries.

Энэ онд Япон улс, Монгол улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ой тохиож байгаа бөгөөд он гарсанаас хойш хоёр орны Парламентын дарга нарын харилцан айлчлал, Япон, Монголын Стратегийн түншлэлийг бодитой болгохын тулд шинэ Дунд хугацааны 5 жилийн хөтөлбөрийг батласан зэрэг олон үр дүн дагуулсан ололт амжилтаар дүүрэн жил байлаа. Мөн энэхүү чухал тэмдэглэлт ойг тэмдэглэн өнгөрүүлэхийн тулд Япон, Монголын олон хүний дэмжлэгтэй зохион байгуулагдсан төрөл бүрийн соёлын арга хэмжээ хийгээд хамтарсан симпозиум зэргийг нэг бүрчлэн дурдах боломжгүй юм.

The close relationship that we enjoy today between our two countries has not simply been shaped by the passage of time. It is indeed the result of our joint efforts, by the governments and the peoples, to deepen our friendship and cooperation in a great variety of areas over the years, particularly since 1990 when Mongolia came to share our values through its democratisation.

Өдгөө ийнхүү ойртон нягтарсан Япон, Монгол орны харилцаа нь дан ганц 45 жил хэмээх цаг хугацааны урсгалаар бий болсон зүйл биш бөгөөд хоёр орны Засгийн газар болоод ард иргэд ялангуяа 90 оны Монгол улс ардчилалд шилжсэнээс хойш нийтлэг үнэт зүйлсийг хуваалцан тухайн салбар бүрт нөхөрлөл, харилцаа холбоо, хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлсний үр дүн билээ.

It is against such background that we are gathered here tonight to celebrate the birthday of His Majesty. I would like to take this opportunity to thank and congratulate each of the individuals and institutions, who have worked over the 45 years to advance our relationship this far to the level of strategic partnership.

Энэ утгаараа өнөө орой Та бүхэнтэй Эзэн Хааны мэндэлсэн өдрийг тэмдэглэхийн хамт энэхүү завшааныг ашиглан энэ 45 жилийн турш хоёр орны харилцааг Стратегийн түншлэл болгон хөгжүүлсэн ахмад үеийнхэн болоод энд хүрэлцэн ирсэн хүн нэг бүрийн хүчин чармайлтад талархаж, баяр хүргэж байгаагаа илэрхийлье.

Баярлалаа.